# ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭГ САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2026.06.12

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Биелэлт |
|---|---|---|---|---|
| 1. | Холбогдох хууль, дүрэм, журам, АТГ-аас гаргасан шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, ном, гарын авлага зэргийг төвийн албан хуудас, пэйж хуудас, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, байршуулах, боломжит бүх хэлбэрээр албан хаагчдад мэдээлэл хүргэх | Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд байршуулсан тоо | Нээлттэй болгохоор хууль, журамд заасан мэдээллийг цахим системд байршуулсан байна. | ЭМЯ-аас өгсөн чиглэлийн дагуу байгууллагын цахим хуудсанд Авлигыг мэдээллэх утсыг шинэчлэн, 2 бичлэг байршуулсан.    |

https://bloodcenter.mn/

Байгууллагын ХАСХОМ мэдүүлдэг холбогдох албан тушаалтнуудад ХАСХОМ мэдүүлэх болон https://meduuleg.iaac.mn/ программын шинэчлэлтэй холбоотой мэдээллийг өгч,
Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргах нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлагыг олгосон.



Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргах нийтийн албан тушаалтнуудад зориулсан

ГАРЫН АВЛАГА -2025 он

2025.04.24

| № | Овог нэр | Албан тушаал | Хүлээн авсан гарын үсэг |
|---|---|---|---|
| 1 | Б.Нарантуяа | ЦССҮТ-ийн захирал | |
| 2 | Л.Энхчимэг | СХА-ны дарга | |
| 3 | Э.Тунгалагтуяа | ТҮЧАБА-ны дарга | |
| 4 | Б.Оргил | БҮА-ны дарга | |
| 5 | Н.Цэрэндэжид | НЛА-ны дарга | |
| 6 | Б.Одонтунгалаг | ЦДЗБА-ны дарга | |
| 7 | | | |
| 8 | | | |

Гарын авлага хүлээлгэн өгсөн: ЦССҮТ-ийн ЭБАТ У.Наранцэцэг




Мөн Сайтын ил тод байдал цэс дотор Авлигын эсрэг цэсийг үүсгэн, тус цэс дотор:

- Хууль тогтоомж,
- Төлөвлөгөө, тайлан,
- Олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа
- Мэдүүлэг гаргагч танаа дэд цэсүүдийг үүсгэн холбогдон мэдээллүүдийг холбож оруулсан.



| | | | | |
|---|---|---|---|---|
| 2. | Төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа, тендерийн мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн дагуу цаг тухайд нь мэдээллэх | Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээний хувь | Үнэлгээний хувь 95% -с дээш байх | Шилэн дансны тухай хуулийн дагуу тухай бүр мэдээллийг оруулсан. https://shilendans.gov.mn/organization/12784?ry=2026&group=117   |
| 3. | Олны танил хүмүүсээр байгууллагын үйл ажиллагааг сурталчлуулсан зэрэг бичлэг, пост мэдээлэл цахим системд оруулах зэрэг нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах | Хамтран ажилласан олны танил хүмүүсийн тоо, хийлгэсэн сурталчилгааны тоо . | 5-аас доошгүй хүмүүсээр байгууллагын сурталчилгааг хийлгэсэн байна. | УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн, А.Ариунзаяа, Л.Соронзонболд, Г.Хосбаяр, МУСТА дуучин Л.Чулуунбаатар, жүжигчин Б.Батболд, МУ-ын начин Д.Амарсайхан нартай хамтран богино хэмжээний видео бичлэг хийж, байгууллагын цахим хуудсанд байршуулан, түгээсэн. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | Цус сэлбэлт судлалын үндэсний төв<br>8h ·<br>Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Цусны донорын Дэлхийн өдрийг тохиолдуулан хүмүүнлэг сэ... See more<br><br>Цус сэлбэлт судлалын үндэсний төв<br>1d ·<br>Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нийт иргэдээ авлагагүй, сайн дурын цусны донор болж хү... See more<br><br>Цус сэлбэлт судлалын үндэсний төв<br>1d ·<br>Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд хэрхэн цусны донор болсон тухайгаа бидэнтэй хув... See more<br><br>Цус сэлбэлт судлалын үндэсний төв<br>2d ·<br>Цусны донорын Дэлхийн өдрийг тохиолдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр нийт цусны до... See more<br> |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | |   |
| 4. | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд бүрийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг АТГ-аар хянуулж, дүгнэлт гарсны дараа томилгоог баталгаажуулах | АТГ-ын хяналтад хамрагдсан томилгооны хувь | Тухай бүр АТГ-т ХАСУМ-ийг хянуулсан байна. | Нийтийн албанд томилогдохоор 2026 оны 1 дүгээр сард нэр дэвшсэн 2 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг 10, 11 тоот албан бичгээр АТГ-т хүргүүлэн хянуулж, 1 эмчийг удирдах албан тушаалд томилсон. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | <br>Мөн 4 сарын 15-ны өдрөөс систем шинэчлэгдсэн холбоотой Бодлого, төлөвлөлтийн албаны дарга, ахлан нягтлан бодогчийн албан тушаалд нэр дэвшсэн Н.Буянхишигийн ХАСУМ-ийг хянуулахаар системээр илгээсэн болно. |
| 5. | АТГ, ЭМЯ-аас өгсөн чиглэлийн дагуу программын шинэчлэлтэй холбоотой тухай бүр сайжруулж, цаг үеийн нэмэлт өөрчлөлтийг хийх | АТГ, ЭМЯ-аас ирсэн зааварчилгаа, зөвлөмжийн тоо | АТГ, ЭМЯ-аас ирсэн зааварчилгааны дагуу холбогдох өөрчлөлтийг хийсэн байна. | АТГ, ЭМЯ-аас ирсэн чиглэлийн дагуу программын шинэчлэлтэй холбоотой https://meduuleg.iaac.mn/ -д нийт 9 албан тушаалын тодорхойлолтыг бүртгэн оруулсан. |
| 6. | Байгууллагын удирдах ажилтан болон нийт албан хаагчдын авилга, ашиг сонирхлын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, мэдээллээр хангах | - Зохион байгуулсан үйл ажилагаа, сургалтын тоо,<br>- хамрагдсан хүний тоо, | Улирал бүр сургалт зохион байгуулж, албан хаагчдын 90% -с дээш хувийг хамруулах | Байгууллагын удирдах албан тушаалтан буюу албаны дарга 4, ахлах мэргэжилтэн 8, нийт 12 албан хаагчдыг 2026 оны 6 сарын 10-11-ний өдрүүдэд Удирдлагын академийн “Эрүүл мэндийн байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах нь” сэдэвт сургалтад хамруулсан.<br>Тус сургалтад “Авилга, ашиг сонирхлын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр 4 цагийн сургалт орсон.<br>*/Сургалтад хамрагдсан албан хаагчдын үнэмлэхийг хавсаргав/* |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | <br>ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫГ ЧАДАВХЖУУЛАХ НЬ<br><br>ҮНЭМЛЭХ |
| 7. | Үйлчлүүлэгч төвтэй, хүндэтгэлтэй харилцаа, ёс зүйд суурилсан чанартай тусламж, үйлчилгээний соёлыг төлөвшүүлэх хүрээнд ёс зүйн аян зохион байгуулах | Аян зохион байгуулах, албан хаагчдын оролцооны хувь | Аян зохион байгуулж, албан хаагчдын 90% -с дээш хувийг хамруулах | ЦССҮТ-ийн захирлын 4 сарын 30-ны өдрийн "ЁС ЗҮЙН ЭЕРЭГ НӨЛӨӨЛӨЛ" сарын аян зохион байгуулах удирдамж, төлөвлөгөөг батлуулсан.<br>Тус батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу алба бүр 7; 7 хоногоор хувиарлан авч, нийт 23 ажлыг зохион байгуулж, байгууллагын албан хаагчдыг 80 дээш хувь хамруулсан. |

БАТЛАВ.
ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЗАХИРАЛ Б.НАРАНТУЯА
2026 оны [illegible] дугаар сарын 30

**"ЁС ЗҮЙН ЭЕРЭГ НӨЛӨӨЛӨЛ" СЭДЭВТ САРЫН АЯНЫ УДИРДАМЖ**

**Уриа:**

1."Ажилтны ёс зүй-Байгууллагын үнэлэмж"

2."Цусны донор би-Ёс зүйтэй хүмүүнлэгийн үйлстэн"

**Үндэслэл:**

1. Байгууллагын соёл нь ажилтнуудын ёс зүйтэй харилцаа, хандлага, үнэт зүйл, зан үйлийн нэгдмэл байдлаар илэрч, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөө, үйлчилгээний чанарт шууд нөлөөлдөг. Байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд зөвхөн удирдлагын манлайлал бус нийт ажилтнуудын идэвх, оролцоо, хариуцлага чухал үүрэгтэй.

Ажлын байранд харилцааны соёл, ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, бие биенээ хүндэтгэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх нь эерэг уур амьсгал, ажлын орчныг бүрдүүлэх, зөрчил маргаанаас урьдчилан сэргийлэх, байгууллагын нэр хүндийг дээшлүүлэх үндэс болдог.

2. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн үндсэн үйл ажиллагааны чухал хэсэг болох донор үйлчлүүлэгчдийн ёсзүйн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, эерэг харилцаа хандлагыг төлөвшүүлэх шаардлага үүсэж байна.

Иймд байгууллагын соёлыг төлөвшүүлэх, эерэг хандлага, зөв дадлыг хэвшүүлэхэд ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх, донор үйлчлүүлэгчдийн ёсзүйн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор ёс зүйн сарын аяныг зохион байгуулж байна.

**Зорилго:**

Байгууллагын соёл, уур амьсгалыг эерэг болгох, эмч эмнэлгийн мэргэжилтэн хоорондын харилцаа, хандлагыг сайжруулах.

Донор үйлчлүүлэгчдийн ёс зүйн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх;

Олон нийтэд донорын талаарх эерэг ойлголтыг нэмэгдүүлэх;

**Хамрах хүрээ:** Төвийн ажилтнууд, донор үйлчлүүлэгчид

БАТЛАВ.
ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЗАХИРАЛ Б.НАРАНТУЯА
2026 оны [illegible] дугаар сарын 20

**"ЁС ЗҮЙН ЭЕРЭГ НӨЛӨӨЛӨЛ" СЭДЭВТ САРЫН АЯНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хугацаа | Хариуцах ажилтан | Шалгуур үзүүлэлт |
|---|---|---|---|---|
| 1. | Аяны нээлт, Аяны хүрээнд ажилтан бүрт зориулсан эерэг үг бэлтгэж, тараах | 2026.05.01 | Ёс зүйн салбар хороо Э.Тунгалагтуяа | Нээлтэд оролцсон ажилтнуудын тоо |
| 2. | Дотоод сүлжээнд ёс зүй, харилцаа хандлагын талаарх мэдээлэл түгээх | 2026.05.01-05.08 | Ёс зүйн салбар хороо Б.Оюунцэцэг, Б.Ихбаатар | Түгээсэн мэдээлэл, постын тоо, түгээсэн мэдээлэлтэй танилцсан ажилтнуудын тоо |
| 3. | "Аз жаргалтай ажлын байр" богино хэмжээний бичлэг хийх | 2026.05.04-05.08 | Ёс зүйн салбар хороо Б.Өнөрцэцэг | Бичлэгт оролцсон ажилтнуудын тоо |
| 4. | Ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгаа | 2026.05.01-05.08 | Ёс зүйн салбар хороо Б.Ниндбадрах | Судалгааны дүгнэлт |
| 5. | Сургалт зохион байгуулах | 2026.05.07 | Ёс зүйн салбар хороо | 1 удаагийн сургалт хийгдсэн байна. Сургалтад хамрагдсан эмч ажиллагсдын тоо |
| 6. | Дараагийн албанд үйл ажиллагаа шилжүүлэн өгөх | 2026.05.08 | Ёс зүйн салбар хороо | |
| 7. | "Инээмсэглэл-Эерэг хандлага" өглөөний мэндчилгээ, угталт | 2026-05-11 | Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн алба | Тайлан, зураг, төвийн хаалттай груп байршуулах |
| 8. | "Талархал" захидал илгээх, Амрах хэсгийн самбар болон төвийн хаалттай группэд байршуулах 5 өдөр | 2026-05-12 | Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн алба | Тайлан, талархал, зураг |
| 9. | "АХА" тэмцээн зохион байгуулах | 2026-05-13 | Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн алба | Асуулт, зургаар тайлан |

Төвийн нийт албан хаагчдад чадавхжуулах, мэдлэг олгох, нэмэгдүүлэх зорилгоор:

- 5 сарын 26-ны өдөр "Байгууллагын соёл үйлчилгээнд

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | мөрдөх журам” сэдэвт сургалтыг ТҮЧАБА-аас зохион байгуулж, 33 албан хаагчийг,<br>- 5 сарын 20-ны өдөр “Анагаах ухааны ёс зүй” сэдэвт сургалтыг АШУҮИС-тай хамтран НЭМС-ийн багш Ц.Мөнхсайхан удирдан, зохион байгуулж, нийт 55 албан хаагчийг,<br><br>- 5 сарын 07- ны өдөр “Ажил, амьдралын тэнцвэртэй байдал” сэдэвт сургалтыг гэр бүл судлаач, доктор, дэд профессор Б.Оюун-Эрдэнэ удирдан, зохион байгуулж, 31 албан хаагчийг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | <br>4 сарын 30-ны өдөр “Жендерийн орчин цагийн хандлага, сэтгэл зүйн асуудлууд” сэдэвт сургалтыг ДХИС-тай хамтран зохион байгуулж, сургалтыг Нийгмийн ухааны тэнхимийн багш, доктор, профессор Цагдаагийн хошууч А.Баярцэцэг удирдан зохион байгуулж, нийт 34 албан хаагчийг тус тус хамруулсан.<br> |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8. | Авилга, ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах олон сувгийн /утас, цахим, саналын хайрцаг/ тогтолцоог бүрдүүлж, мэдээлэгчийн нууцлалыг хангаж, шийдвэрлэх | - Ажиллаж буй гомдол, мэдээллийг хүлээн авах сувгийн тоо /утас, цахим, саналын хайрцаг г.м/<br>- Ирсэн гомдол, мэдээллийн ба шийдвэрлэлтийн тоо | - 2-оос доошгүй суваг ажилладаг байх<br>- Ирсэн гомдлын 90%-с дээш шийдвэрлэсэн байх | Авилга, ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг утас, болон саналын хайрцагаар хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.<br>Эхний хагас жилийн байдлаар ирсэн гомдол, мэдээлэл ирээгүй. |
| 9. | Сул орон тоонд хуулийн дагуу нээлттэй сонгон шалгаруулалт зарлах | Холбогдох хууль, журмын дагуу хийсэн томилгооны тоо | Холбогдох хууль, журмын дагуу хийсэн томилгоо хийсэн байна. | Эхний хагас жилийн байдлаар 9 мэргэжлийн чиглэлээр 4 удаагийн давтамжтайгаар сул орон тооны сонгон шалгаруулалтыг байгууллагын цахим хаягаар нээлттэй зарласан.<br>Журмын дагуу сонгон шалгаруулалтыг нийт 9 албан хаагчийг холбогдох албан тушаалд томилсон. |

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН: [signature] У.НАРАНЦЭЦЭГ /ЦССҮТ-ИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН/